



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх зорилтын 3.1.3, 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар зорилтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудын дунд зохион байгуулах “ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН” аяны удирдамжийг нэгдүгээр, уг аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН” аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг эрүүл мэндийн даатгалын сан, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл тусламж, дотоод эх үүсвэрээс нэмэлтээр гаргах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

3. Аяныг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, байгууллагын захирал нарт тус тус даалгасугай.

4. Аяныг улсын хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллах, хувийн хэвшил, бусад салбарын эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулан, үр дүнг дөрөвдүгээр улиралд багтаан тайлагнахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080366

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 23-ны өдрийн  
А/108 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

## “ЭРҮҮЛ МЭНД-ЭЭЛТЭЙ ОРЧИН” АЯНЫ УДИРДАМЖ

### Үндэслэл

Вирүст хепатит нь дэлхийд хамгийн их тархсан халдварт өвчний нэг бөгөөд эрүүл мэндийн нэн тулгамдсан асуудал болж байна. Дэлхий дээр 520 сая гаруй хүн вирүст хепатитын архаг халдвартай ба үүнээс 1.45 нь сая нь жил бүр уг өвчнөөс үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдраар нас барж байна. Вирүст хепатитын шалтгаант нас баралтын 48 хувь нь В, 48 хувь С, бусад нь цочмог А, Е вирүст халдвар эзэлж байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах, орчин үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай авах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэх бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөнд Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо бий болгох 3.1.3-т “Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирүсийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварын тархалтыг таслан зогсоох, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн.

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 186 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллага дахь халдварын сэргийлэлт, хяналтын зохион байгуулалт, эрүүл мэндийн яамны дэргэдэх халдварын сэргийлэлт хяналтыг зохицуулах чиг үүрэг бүхий зөвлөл, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад хийгдэх үйл ажиллагааны жагсаалт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг журамласан.

Манай улс элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралт өндөртэй улс орнуудын тоонд орж, сүүлийн арван жилд элэгний хорт хавдрын нас баралт тасралтгүй нэмэгдсээр нийт нас баралтын 15 хувийг элэгний өвчлөлөөс шалтгаалах нас баралт эзэлж байна.

Монгол Улсад 2013 онд нийтдээ 200,000 хүн архаг хепатит С вирүсийн халдвартай буюу тархалтын түвшин 6,8%-тай гэж тооцоолсон байна. Цусан дахь вирүсийн түвшин /вирүсеми/ 70 орчим хувь гэж тооцоолсон бөгөөд анти-ХСВ-ийн эсрэг биеийн тархалт нь 9,8% (285.700 тохиолдол). Өнөөдөр тархалтын тооцоолол нийт хүн амын дунд хийсэн судалгаа ( О.Баатархүү, 2008), харин бага тархалтын тооцоолол цусны доноруудын дунд хийсэн судалгаан дээр үндэслэн гарсан (Цэрэнпунцаг, 2008) байна.

Судлаач М.Мөнхнасан, Д.Даваалхам (2011) нарын судалгаанд хот, хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын бүх шатлалд ажиллаж буй 1000 гаруй

эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулсан судалгаагаар 68,2%-д anti-HBc, 7.69%-д HBsAg, 21.9%-д нь анти-HCV маркер тус тус эерэг тодорхойлогдож, 0,7% нь ХВВ ба ХСВ-ийн хавсарсан халдвартай болох нь тогтоогджээ. ХСВ-ийн халдвар илэрсэн эмнэлгийн мэргэжилтнүүдийн бараг тал хувь (46.2%)-д HCV RNA илэрсэн нь вирүсийн идэвхжил өндөр байгааг илэрхийлсэн анхаарал татсан үзүүлэлт байлаа. Газар зүйн бүс болон хот, аймаг, сумдаар болон эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, үйлчилгээний ажилтан зэрэг ажил мэргэжлийн төрлөөр харьцуулж үзэхэд халдварын тархалт ойролцоо өндөр байна. Эрүүл мэндийн ажилтнуудын дийлэнх нь ажлын байран дээрээ тариур, иртэй багажинд хатгуулж байсан ба жилд дунджаар 2,3 удаа хатгалтанд өртдөг байна. Эрүүл мэндийн байгууллагад ажилласан жил эрсдэлт хүчин зүйл болж байгаа бөгөөд ажилласан жил нэгээр нэмэгдэхэд халдвар авах эрсдэл 10%-иар ихсэж байгааг судлаачид тогтоожээ.

### **Зорилго**

Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнуудыг халдвараас урьдчилан сэргийлэх, оношилох, эмчлэх, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах

### **Зорилт**

- Эрүүл мэндийн ажилтнуудын дунд хепатитийн “С” вирүсийн тархалтыг тогтоох
- Хепатитийн “С” вирүс илэрсэн эрүүл мэндийн ажилтнуудын дунд вирүсийн идэвхжилийг тодорхойлж, эмчилгээнд хамруулах
- Эрүүл мэндийн ажилтнуудын эрүүл мэндийн мэдээний сан байгуулах

**Хамтран зохион байгуулах баг:** Эрүүл мэндийн яам, Батлан хамгаалах яам, Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээвэр хөгжлийн яам, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

### **Хамрах хүрээ:**

Эрүүл мэндийн яам, харьяа байгууллагууд, Монгол Улсын хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтнууд

**Хугацаа:** 2017 оны 03-12 сар

**Санхүүжилтийн эх үүсвэр:** Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, Олон улсын байгууллагууд, Эрүүл мэндийг дэмжих сан, эм ханган нийлүүлэх байгууллагууд


### **Үйл ажиллагаа:**

1. Монгол улсын хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн ажилтануудын дунд хепатитийн “С” вирүсийн халдварыг илрүүлэх үйл ажиллагааг 2017 оны 04 сард багтаан үе шаттай зохион байгуулна.

2. Хепатитийн “С” вирусийн халдварын ачаалалыг тоолох шинжилгээ, түүний үр дүнг 05 сард багтаан зохион байгуулна.
3. Хепатитийн “С” вирусийн халдвартай эмнэлгийн ажилтануудыг 12 сард багтаан эмчилгээнд бүрэн хамруулна.

**Үр дүн:**

1. Эрүүл мэндийн салбарын ажилтанууд С вирусийн халдваргүй болсон байна.
2. Хепатитийн “С” вирусийн шинжилгээ, оношилгоо, эмчилгээний тандалтын тогтолцоог үндэсний хэмжээнд нэвтрүүлнэ.
3. Хепатитийн “С” вирүст халдварын үндэсний хэмжээний судалгаа бий болно.
4. Хепатитийн “С” вирүст халдварыг илрүүлэх лабораторийн оношилгоонд олон улсын шаардлага хангасан хяналтыг бий болгоно.
5. Эрүүл мэндийн ажилтануудын дунд хепатитийн “С” вирусийн халдварыг оношилж, эмчлэн вирусийн голомтыг устган халдварт тархалтыг таслан зогсооно.
6. Төр, хувийн хэвшлийн эрүүл байгууллагуудыг татан оролцуулж хамтран ажиллана.
7. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын эрүүл мэндийн мэдээний санг байгуулна.
8. Эрүүл мэндийн салбарын лаборатори, сорьц тээвэрлэхтэй түүнтэй холбоотой бодлогын баримт бичгүүд боловсронгуй болно.



Эмнэлгийн ажилтнуудын дунд элэгний С вирусийн халдварыг оношлон, эмчлэх ерөнхий зураглал

